



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ  
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ  
MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY



# ШУТИС-ИЙН БАГШ АЖИЛТАНЫ ЁС ЗҮЙН ШИНЭЧИЛСЭН ДҮРЭМ



Зохион байгуулагч: ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөл

## ШУТИС-ИЙН БАГШ АЖИЛТАНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Анх Ректорын 2007 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 273 тоот тушаалаар “ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн дүрэм”, “ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөлийн ажиллах журам” батлагдсан.

Захирлын 2015 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А/184 тоот тушаалаар шинэчлэн боловсруулж баталсан.

## ШУТИС-ИЙН БАГШ АЖИЛТАНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- “ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн дүрэм”, “ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг нэгтгэж **“ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн дүрэм”** дүрэм болгосон.
- “ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн дүрэм”-д **56** заалтыг шинээр, **39** заалтад өөрчлөлт оруулж, **15** заалтыг хүчингүй болгосон байна.

• ШУТИС-ийн захирлын зөвлөлийн **2021 оны 12 сарын 07-ний** өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2021 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/246

Улаанбаатар хот

"ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм"-ийг  
шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, ШУТИС-ийн дүрмийн 4.14.7, 10.2 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны чиглэл хүргүүлэх тухай 2020 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 2/1174 тоот албан бичиг, ШУТИС-ийн захирлын зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм"-ийг хавсралтаар шинэчлэн баталж, 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс мөрдсүгэй.

2. "ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм"-ийг нийт багш, ажилтнуудад танилцуулж, үйл ажиллагаанд мөрдүүлж, хэрэгжүүлж ажиллахыг Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал (Н.Ганзориг), Захиргаа, хүний нөөцийн газрын дарга (Ж.Арслан), ШУТИС-ийн ёс зүйн зөвлөлийн дарга (Д.Оюун) нарт даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Захирлын 2015 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн "Дүрэм, журам батлах тухай" А/184 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ

ШУТИС-ийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/246 дугаар тушаалын хавсралт



	ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм ШУТИС-ХН-ДҮ01	Эхний хэвлэл	2007.10.22
		Өөрчилсөн огноо	2021.12.24
		Өөрчлөлтийн дугаар	3

## ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм

Боловсруулсан:

ШУТИС-ийн ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ

Хянасан:

ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЛБА

Дэмжсэн:

ШУТИС-ийн ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-ийн ЗАХИРАЛ

ШУТИС-ийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/246 дугаар тушаалын хавсралт



АГУУЛАГ

.....	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШЛЭЛ	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЕО, ТОДОРХОЙЛОЛТ	3
ТАВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	4
ЗУРГАА. БАРИМТЛАХ ЗАРЧИМ	5
ДОЛОО. ҮҮРЭГ БОЛГОСОН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ	5
НАЙМ. ЁС ЗҮЙН ХОРИГЛОХ ХЭМ ХЭМЖЭЭ	7
ЕС. ЗӨВЛӨЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА	9
АРАВ. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ	10

<https://must.edu.mn/media/uploads/2022/01/04/2021-12-24-a246-tushaal-yos-zuin-durem.pdf>

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү дүрмийн эрхэм зорилго нь их сургуулийн багш, ажилтан, гэрээгээр ажил гүйцэтгэж буй бусад байгууллагын ажилтан, орон тооны бус зөвлөлүүдийн гишүүн /цаашид багш, ажилтан гэх/ нь сургалт, эрдэм шинжилгээ болон нийгэмд үзүүлэх үйлчилгээ, хүний эрх, эрх чөлөө, үнэ цэнэ, тэдгээрийг хүндэтгэх үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх үндсэн чиг үүргээ хариуцлагатай биелүүлэх болон ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх харилцааг зохицуулахад оршино.

Багш, ажилтны нийгэм, сургууль, хамт олонтой хамтран ажиллах болон хүлээх хариуцлага, эдлэх эрх чөлөө, эзлэх байр суурийн харилцан уялдаа холбоог зохицуулах нь энэхүү дүрмийн үндэс юм.

ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөл нь /цаашид Зөвлөл/ их сургуулийн хэмжээнд багш, ажилтны ёс суртахуун, ёс зүйн хэм хэмжээний асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий орон тооны бус зөвлөл юм.

## ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- Энэхүү дүрэм нь ШУТИС-ийн багш, ажилтан, гэрээгээр ажил гүйцэтгэж буй бусад байгууллагын ажилтан, орон тооны бус зөвлөлүүдийн гишүүнд хамаарах ёс зүйн өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх болон ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулна.



## ГУРАВ. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Монгол улсын Үндсэн хууль

Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

Хөдөлмөрийн хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль

Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм

Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн нийтлэг дүрэм

Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага

ШУТИС-ЧХ-ЖУ02 Өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх журам

ШУТИС-ийн дотоод дүрэм, журам, хамтын гэрээ

## ДӨРӨВ. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

**Боловсролын байгууллагын ёс зүйн хэм хэмжээ:** Их сургуулийн сонирхогч талууд тэгш эрхтэйгээр харилцаж, сонирхлын зөрчлөөс зайлсхийж, нийгмийн ашиг тусын тулд үйл ажиллагаа явуулах ёс зүйн мэргэжлийн орчныг бий болгох чадвар.

**Орон тооны бус зөвлөлүүдийн гишүүн:** ШУТИС-ийн удирдах зөвлөл, эрдмийн зөвлөл, эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн.

**Ялгаварлан гадуурхалт:** Аливаа хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхах үзэл.

**Эрх тэгш хандах:** Нас, хүйс, арьсны өнгө, нийгэм, эдийн засгийн байдал эсвэл бусад ялгарах шинж чанар, ялгаатай байдлаас үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхах, давуу эрх олгохгүйгээр **хуулийн өмнө** хүн бүрт ижил тэгш хандах.

**Хүчирхийлэл:** Эрх бүхий этгээд эрх мэдэл, албан тушаалын хүрээнд бусдад бие болон сэтгэл зүйн дарамт, шахалт, сүрдүүлэг зэрэг хуулиар хориглосон болон мэргэжлийн ёс зүйд үл нийцэх үйлдэл, эс үйлдэхүй.



## ДӨРӨВ. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

**Дарамт:** Бусдыг хүсээгүй байхад үг хэлээр, биеэр болон өөр бусад хэлбэрээр ажил, албан тушаал, эд материал, бие махбодь, сэтгэл санаа, бэлгийн болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх.

**Ёс зүйн зөрчил:** ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэмд тусгасан ёс зүйн үүрэг болгосон, хориглосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй.

**Ёс зүйн зөрчил гаргагч:** ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэмд заасан ёс зүйн үүрэг болгосон, хориглосон хэм хэмжээг зөрчсөн нь ёс зүйн зөвлөлөөр тогтоогдсон багш, ажилтан.


**Био ёс зүй:** Хүнийг шууд ба шууд бус оролцуулан хийх шинжлэх ухааны тодорхой чиглэлийн судалгаанд баримтлах хэм хэмжээ.

**Цахим ёс зүй:** Цахим болон цахим хэрэгсэл болох интернэт, ухаалаг утас, төрөл бүрийн програм хангамж, нийгмийн сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдийн бие даасан байдал, нэр төрийг хүндэтгэх зорилготой хэм хэмжээ.

## ТАВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

### ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн зөвлөл

- ШУТИС-ийн хэмжээнд багш, ажилтны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлыг шийдвэрлэх;
- Их сургуулийн хэмжээнд ёс зүйн дүрмийг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах;
- Багш, ажилтныг буруугүй гэж үзвэл түүний эрх ашиг, нэр хүндийг хамгаалах, сэргээх;
- Ёс зүйн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал гаргах;
- Ёс зүйн хэм хэмжээний талаар сургалт, сурталчилгааг төлөвлөх, хэрэгжүүлэх.



## ЗУРГАА. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Хуулиар олгогдсон эрхээ эдлэх, хэрэгжүүлэхдээ бусдын нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэнэ.

Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх суурь эрх чөлөөг хүндэтгэнэ.

Мэдлэг олгох, сурч боловсрох эрх ашгийг урьтал болгох, судалгааны ажлын эрх чөлөөг хүндэтгэх, мэргэжлийн үнэ цэнийг хамгаалахыг эрмэлзэнэ.

Нийгмийн хариуцлагыг ухамсарлан хүн бүрт хүртээмжтэй, аюулгүй, эрүүл таатай орчинд ажиллах, суралцах боломж олгоно.

Суралцагч болон хамт олонд итгэл үнэмшил, шашин шүтлэг, улс төрийн болон нийгмийн байр суурийн талаарх хувийн үзэл бодлоо шууд болон шууд бусаар тулган хүлээлгэхгүй, нөлөөлөхгүй байна.

Зөвлөлийн гишүүдийн баримтлах зарчим:

- Зөвлөлийн хурал дээр хэлэлцсэн асуудал болон зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг нууцлах;
- Аливаа асуудалд эрх тэгш, шударга хандах
- Хэлэлцэж асуудалд хувийн ашиг сонирхлоор хандахгүй байх;

## ДОЛОО. ҮҮРЭГ БОЛГОСОН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

### 7.1 НИЙТЛЭГ ДАГАЖ МӨРДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ:



Үнэн, шударга ёсыг дээдэлж, үг хэлээр гутаан доромжлох, дорд үзэхээс ангид байна.



Багш, ажилтан, суралцагч, хамт олон, сургуультай холбоотой мэдээллийг хууль бусаар ашиглахыг тэвчиж, хадгалдаг байна.



Суралцагч, хувь хүн, хамт олны эрх ашгийг чухалчилж, аливаа харилцаанд мэргэжил, албан тушаал, эрх мэдлийн нэр хүндийг эрхэмлэнэ.



Бусдын бие махбодь, сэтгэл зүй, санхүүгийн ашиг сонирхлыг хүндэтгэнэ.



Цахим орчин болон олон нийтийн сүлжээнд байгууллагын нэр хүндийг өргөж, аливаа зөрчлөөс ангид байна.



Аливаа асуудалд хараат бусаар бодитой хандаж, үндэслэлтэй, ил тод шийдвэр гаргадаг байна.

## ДОЛОО. ҮҮРЭГ БОЛГОСОН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

### 7.1 НИЙТЛЭГ ДАГАЖ МӨРДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ:



Бусдыг бүх хэлбэрийн дарамтад оруулахгүй, хувь хүний тэвчишгүй орчин үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.



Бусдыг арьс өнгө, хэл соёл, угсаа гарвал, нас, хүйс, үзэл бодол, амьдралын нөхцөл, хөгжлийн онцлог байдал болон хувийн шалтгаанаар ялгаварлан гадуурхахгүйгээр боловсролын үйлчилгээг эрх тэгш, хүртээмжтэй хүргэнэ.



Хамт ажиллаж байгаа хүмүүсийн эрдмийн болоод хувийн эрх чөлөөг хүндэтгэнэ.



Сургууль, хамт олны удирдлагын үйл ажиллагаанд багш өөрийн санал, бодлыг ил тод илэрхийлж оролцоно.



Хамт олны дунд эерэг уур амьсгалыг бүрдүүлнэ.



Гоо зүйн хэм хэмжээг баримтална.

## 7.2 СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН:



Багш сургахуйн үйл ажиллагааг чиглүүлэн дэмжигч, удирдагч, зөвлөгч нь байна.



Багш нь суралцагчдад бүх талаараа зөв үлгэр дуурайллыг үзүүлнэ.



Багш нь суралцагчийн мэдлэг чадварыг бодитой, үнэн зөв, шударга дүгнэж үнэлнэ.



Багш бүтээлч байж, ажил үүргээ мэргэжлийн өндөр түвшинд санаачлагатай, шударгаар биелүүлнэ.



Ажил хэрэгч бодит санал шүүмжлэлийг хүлээн авч, аливаа асуудлыг эв зүйгээр шийдэж, эерэг уур амьсгал бүрдүүлнэ.

### 7.3. СУДАЛГААНЫ АЖЛЫН ХҮРЭЭНД:



Бусад багш, судлаачийн өөр үзэл бодол, байр суурь, хандлагыг хүндэтгэнэ



ШУТИС-ийн болон харьяа сургууль, алба, нэгж, төвийн нэрээр аливаа судалгааны төсөл, гэрээт ажил удирдах, гүйцэтгэх тохиолдолд заавал мэдээлж, хэлэлцүүлж, тайлагнаж байна



Судалгаа, эрдэм шинжилгээний ажилд залуу багш, судлаач, суралцагчдын оролцоог дэмжиж ажиллана



Био ёс зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг мөрдөнө.



Цахим ёс зүйн хэм хэмжээг мөрдөнө.




Судалгааны ажлын хэлэлцүүлэгт танил тал, байгууллагын харьяалал, багш шавийн холбоо зэргээс үл хамааран шинжлэх ухааны ёс зүйн шаардлагыг баримтална.



Сургуулийн байр, техник тоног төхөөрөмж, сургалтын хэрэгсэл хэрэглэгдэхүүн, эд зүйлс, оюуны бүтээлийг зүй зохистой, гамтай ашиглана.

# НАЙМ. ЁС ЗҮЙН ХОРИГЛОХ ХЭМ ХЭМЖЭЭ

## 8.1 НИЙТЛЭГ ХОРИГЛОСОН ХЭМ ХЭМЖЭЭ:



Хувийн ашиг сонирхлын нөхцөл байдал үүсгэх, ямар нэг санал тавих, мэдээлэл сурталчилгаа хийх, зөвшөөрөл олгох, шийдвэр гаргах;

Ажил горилогчийг ажилд авах, албан тушаалд дэвшүүлэх, ажилд томилох, шагнал урамшуулалд тодорхойлох, мэргэжил дээшлүүлэхэд ашиг сонирхлын зөрчил гаргах, ил тод байдлыг үл хангах, илт давуу боломж олгох, боловсрол болон бусад тавигдсан шалгуурт нийцэхгүй хүнийг ажилд ороход нь туслах, туслахыг хүсэх, шаардах;

Мэргэжлийн эсхүл шинжээчийн байр сууринаас олон нийтэд их сургуулийн ажилтны нэрийг ашиглаж хандах тохиолдолд хувийн бодол, үнэлэлт, дүгнэлт гэдгээ үл онцлох;

Урьдчилан зохих зөвшөөрөл авалгүйгээр сургуулийн нэр ашиглан бараа бүтээгдэхүүний реклам, сурталчилгаа хийх;

Албан тушаал, ажил гүйцэтгэх шалгаруулалтад өрсөлдөж байгаа хүний мэдлэг чадварын талаар санаатай худал мэдээлэл тараах;



# НАЙМ. ЁС ЗҮЙН ХОРИГЛОХ ХЭМ ХЭМЖЭЭ

## 8.1 НИЙТЛЭГ ХОРИГЛОСОН ХЭМ ХЭМЖЭЭ:

Хувийн үзэл бодлоо санаатайгаар сургууль, түүний нэгжийн байр суурь хэмээн ойлгуулах;

Бусдыг үндэс, угсаа, хэл, арьс өнгө, нас хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, эрүүл мэндийн онцлог болон хувийн шалтгаанаар ялгаварлан гадуурхах, тэгш бус хандах;

Сургууль, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй болгох;

Сургууль, хамт олны эрх ашигт харшлах шийдвэр гаргах;

ШУТИС-ийн болон харьяа сургууль, алба, нэгж, төвийн тушаал, шийдвэр, тэдгээрийн хавсралтыг санаатайгаар засах, засахыг шаардах;

## НАЙМ. ЁС ЗҮЙН ХОРИГЛОХ ХЭМ ХЭМЖЭЭ

### 8.1 НИЙТЛЭГ ХОРИГЛОСОН ХЭМ ХЭМЖЭЭ:

Аливаа тендер, сонгон шалгаруулалт, худалдах, худалдан авах, боловсон хүчнийг сонгох, тушаал дэвшүүлэх зэрэгт өөрийн хамаатан садан, хувийн ойр дотно харилцаатай найз нөхдийг дэмжих, хувийн ашиг сонирхлын зөрчил гаргах, ялгаварлан гадуурхах;

Хувийн ашиг сонирхолд нийцүүлэн доод тушаалын ажилтан болон суралцагчийн хөдөлмөрийг завших;

Хувь хүний нэр төр, алдар хүндийг унагах үйлдлийг байгууллага, олон нийтэд мэдээлэх, тараах.

Шударга бусаар бусдын нэр төр, байр суурийг гутааж албан тушаал, мэргэжлийн салбарт ахиж дэвших боломжийг хаах, саад учруулах;

Сургалт, судалгааны ажлын хүрээнд улс төржих, үзэл суртал, эрх мэдэл, албан тушаалын байр сууринаас хандах;

## НАЙМ. ЁС ЗҮЙН ХОРИГЛОХ ХЭМ ХЭМЖЭЭ

### 8.2 СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН:

○ Суралцагчтай ажиллах, үнэлэлт дүгнэлт өгөхдөө ялгаварлан гадуурхах, тэгш бус хандах;

○ Албан тушаал, эрх мэдлээ ашиглан суралцагчийн санал бодол, ухамсарт хүчээр нөлөөлөх, үзэл бодлоо тулгах, айлган сүрдүүлэх зэргээр зүй бус авирлах;

○ Суралцагчийн бие махбодид халдах, сэтгэл санааны дарамт учруулах;

○ Суралцагчаас мөнгө нэхэх, ном бүтээгдэхүүн худалдаж авахыг тулгах, хуульд заагаагүй төлбөр, хураамж авах, ном худалдан авсан тохиолдолд давуу нөхцөл үүсгэх;

○ Суралцагчийн хувийн нууцыг задруулах;

○ Суралцагчийг өөрийн эрх ашиг, сонирхлын үүднээс ажиллуулах;

○ Хичээл дээр улс төр, шашны ухуулга, бусад төрлийн сурталчилгаа хийх;

## НАЙМ. ЁС ЗҮЙН ХОРИГЛОХ ХЭМ ХЭМЖЭЭ

### 8.2 СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН:

Шалгалтын материалыг зориуд болон санамсаргүйгээр задлах, давуу эрх олгож шалгалтын хариуг зориуд мэдээлэх;

Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр суралцагчдад хичээл заахаас татгалзах, хичээлд оруулахгүй байх;

Сургуулиас санаачилсан, зохион байгуулсан ажил, үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулах;

Сургуулийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр хувийн болон арилжаа, улс төр, шашны зорилгоор ашиглах;

Бусдыг үүрэгт ажлаа гүйцэтгэхэд нь саад учруулах, заналхийлэх, дарамтлах;

Хамт олны мэргэжлийн болон хувийн зан чанарын талаар суралцагчидтай болон тэдний дэргэд ярилцах;

Бусдын ажил үүргээ гүйцэтгэх явцад хөндлөнгөөс нөлөөлж, өөрийн үзэл бодлоо тулгах, суралцагчийн үнэлгээг заах;

## НАЙМ. ЁС ЗҮЙН ХОРИГЛОХ ХЭМ ХЭМЖЭЭ

### 8.3 Судалгааны ажлын хүрээнд:



Бусдын зохиол бүтээл, судалгаа, нээлтийг санаатайгаар буюу хууль бусаар өөрийн болгох, хамтын бүтээлийг дангаар хийсэн мэт илэрхийлэх; .



Бусдын бүтээл, санааг хулгайлах, эшлэлгүй ашиглах, хуулбарлах, зохиогчийн зөвшөөрөлгүй ашиглах, өөрийн зохиогчийн эрхтэйгээр хэвлэн нийтлүүлэх;



Судалгаанд хамтарч оролцсон багш, ажилтан, суралцагчдын эрх ашиг, нэр төрийг сэвтээх, оролцооны хувь хэмжээг шударга бус үнэлэх;



Бусдын бүтээл, судалгааны үр дүнг үндэслэлгүй шүүмжлэх, шүүмжлэлийг шинжлэх ухааны бус аргаар өрнүүлэх;



Эрдэм шинжилгээний гэрээт болон төслийн ажилд судлаачийн зөвшөөрлийг үл харгалзан оролцуулах, ашиглах;

## НАЙМ. ЁС ЗҮЙН ХОРИГЛОХ ХЭМ ХЭМЖЭЭ

### 8.3 Судалгааны ажлын хүрээнд:



Туршилт, судалгааны үр дүнд бий болоогүй зохиомол өгөгдөл бий болгох, судалгааны ажлыг амжилттай болгох зорилгоор гарсан үр дүнг засах, бусдыг үгүйсгэх, үнэн байдлыг гуйвуулах, тайлагнах;



Судалгааны багийг хувь хүний болон санхүүгийн ашиг сонирхлын зөрчил, эрдэм шинжилгээний зүй бус өрсөлдөөн үүсэхээр бүрдүүлэх;



Хамтын судалгааны явц, үр дүнгийн талаарх мэдээллийг багийн зөвшөөрөлгүйгээр нийтэлж, түгээх;



Судалгааны ажлын хэлэлцүүлгийн явцын маргаан, мэтгэлцээнд бусдыг доромжлох, дарамтлах, баримт нотолгоогүй үгүйсгэл хийх;



Хэлэлцүүлгийн өмнө болон явцад хэлэлцэж буй бүтээлийн талаар хувийн санаа бодлоо бусдад тулгах, далдуур хуйвалдах;

## ЕС. ЗӨВЛӨЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

9.1 Зөвлөл нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн даргаас гадна 10 гишүүнтэй байна.

9.2 Зөвлөлийн гишүүнийг бүрэлдэхүүн сургууль, алба, нэгж, хамт олны хурлаас олонхийн саналаар сонгож, ШУТИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна.

9.3 Зөвлөлийн бүрэлдэхүүний 75-аас багагүй хувь нь сургалтын үйл ажиллагаанд оролцогч байна.

9.4 Зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлага

-Тус сургуулийн үндсэн багш, ажилтан байх;

-Сахилгын зөрчилд холбогдож байгаагүй;

-Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байна. Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаанд гишүүдийн 50 хүртэлх хувийг шинэчилнэ.

## ЕС. ЗӨВЛӨЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

9.5 Зөвлөлийн даргын эзгүйд орлогч дарга түүний эрх, чиг үүргийг хэрэгжүүлнэ.

9.6 Зөвлөлийн хурал нь ээлжит, ээлжит бус байна.

- Ээлжит хурлыг хичээлийн жилийн эхлэл төгсгөлд хийнэ.
- Ээлжит бус хурлыг асуудал хэлэлцэх тохиолдолд зөвлөлийн даргын шийдвэрээр

9.7 Гишүүдийн ирц 70 хувь хүрсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

9.8 Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ.

9.9 Зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтөлж, зөвлөлийн бүх гишүүд танилцаж гарын үсэг зурж баталгаажуулна.

9.10 Судалгааны ёс зүйтэй холбоотой асуудлыг судалж, шийдвэрлэхэд шаардлагатай тохиолдолд тухайн мэргэжлийн эрдэмтдийг ёс зүйн зөвлөлд өргөтгөж ажиллуулж болно.



## ЭС. ЗӨВЛӨЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Зөвлөлийн зардал, урамшуулал

- Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг ШУТИС-ийн төсөвт тусган зарцуулна.
- Зөвлөлийн гишүүний жилийн ажлын урамшуулал нь ажлын гүйцэтгэлээс хамааран ШУТИС-ийн багшийн албан тушаалын нэг сарын цалинтай тэнцэх хэмжээтэй байна.
- Зөвлөлийн үйл ажиллагааны төсвийн зарцуулалтыг ШУТИС-ийн санхүүгийн асуудал хариуцсан албанд тайлагнана.

Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хичээлийн жилд ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хуралд 2 удаа тавина.

Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа болон ёс зүйн зөрчил, хариуцлагын шийдвэрийн талаар багш, ажилтныг таньж болох нэр, хаяг зэрэг мэдээллийг оруулахгүйгээр товч мэдээ бэлтгэж, ШУТИС-ийн веб хуудсанд байршуулан мэдээлнэ.

## АРАВ. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ

Багш, ажилтны ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэхэд “ШУТИС-ЧХ-ЖУ02 Өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх журам”-ыг баримтална.

Багш, ажилтан хамтран өргөдөл, гомдол гаргасан бол түүнд бүгд эсхүл тэдгээрийн төлөөлөл гарын үсэг зурах ба төлөөлөх эрхийг нотлох баримт бичгийг хавсаргасан байна.

Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь ёс зүйн асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэн зөвлөлийн даргад танилцуулж, хуваарилсан гишүүнд гарын үсэг зуруулж, материалыг хүлээлгэн өгнө.

Ёс зүйн зөрчлийн тухай мэдээллийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор хянан судалж, шийдвэрлэнэ. Гомдол, мэдээллийг хянан судлах хугацааг шаардлагатай тохиолдолд нэг удаа ёс зүйн зөвлөлөөс 14 хоногоор сунгаж болно.

## АРАВ. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ

Гомдол гаргагч нь ёс зүйн зөрчлийг судалж, шийдвэрлэх ажиллагааны явцад гомдлоо татаж авах эрхтэй.

Багш, ажилтанд ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл гомдол, мэдээлэл гаргасан хувь хүн, алба, нэгжид энэ тухай бичгээр хариу өгнө.

Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн багш, ажилтанд сахилгын хариуцлага ноогдуулах асуудлыг ёс зүйн зөвлөлөөр эрх хэмжээний хүрээнд хянан хэлэлцэж, хариуцлага ногдуулах саналыг холбогдох алба, нэгж, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

ШУТИС-тай гэрээгээр ажиллаж буй бусад байгууллагын ажилтан ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд үндсэн байгууллагад нь албан ёсоор мэдэгдэнэ.

ШУТИС-ийн багш, ажилтан ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон тохиолдолд түүнд холбогдох хууль тогтоомж, сургуулийн хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу сахилгын шийтгэл ноогдуулна.

## АРАВ. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ

Ёс зүйн хэм хэмжээний зөрчлийн шинж байдлыг харгалзан ёс зүйн зөвлөлөөс анхааруулах, амлалт авахуулах, учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий этгээдэд уламжлах, уучлал гуйхыг үүрэг болгох, сургуулийн захиргаанаас сануулах, хөдөлмөрийн хөлсийг бууруулах, албан тушаал бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах зэрэг Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хариуцлага ногдуулна.

Ёс зүйн зөвлөлийн шийдвэрийг зөрчил гаргагчид бичгээр танилцуулна.

ШУТИС-ийн багш, ажилтан ёс зүйн зөрчил гаргасан нь нотлогдоогүй тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулахыг хориглоно.

Ёс зүйн зөрчил гаргасан үндэслэлээр сахилгын шийтгэл хүлээсэн багш, ажилтан ногдуулсан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдол гаргах эрхтэй.